

МОНГОЛ УЛС ДАХЬ БНХАУ-ЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Н.Томор¹

Хорин нэг дүгээр зууны эхэн үеийн гол онцлог болох дэлхийн эдийн засгийн даяаршил нь хэдийгээр эрсдэл, өрсөлдөөн, боломжийг хамтад нь авчирч буй боловч хөгжиж буй орнууд, түүний дотор Монгол Улс, БНХАУ хоёр улсад үндэсний эдийн засгийг хөгжүүлэх түүхэн боломжийг олгож байна. Монгол, Хятад хоёр улсын эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаанд харилцан бие биеэ түших, нөхөх гольдролоор хөгжиж байна. Нэг талаас Монгол Улс байгалийн асар их баялаг нөөцийнхөө үүцийг нээж, нөгөө талаас БНХАУ-ын том эдийн засгийн үсрэнгүй хөгжил уул уурхай, ашигт малтмалын асар их эрэлт хэрэгцээг үүсгэж байгаа нь хамтын ажиллагаа өргөжих нөхцлийг бүрдүүлж байна. Иймээс ч манай хоёр улс уул уурхай, дэд бүтцийн салбарыг эдийн засгийн хамтын ажиллагааны тэргүүлэх байр гэж тодорхойлсон бөгөөд Хятадын хөрөнгө оруулалт, технологи, хүн хүчийг ашиглан Монголын уул уурхайн салбарт томоохон төслүүдийг хэрэгжүүлж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг БНХАУ-ын зах зээлд гаргах нь ойрын ирээдүйд хамтын ажиллагааны зонхилох хэлбэр болно хэмээн зарим мэргэжилтэн, эрдэмтэд үздэг байна.

Монгол, Хятадын эдийн засгийн харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд манай хоёр улсын дээд хэмжээний харилцан айлчлал чухал ач холбогдолтой. БНХАУ-ын дарга Ху Жинтао Монгол улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн урилгаар 2003 онд Монгол Улсад төрийн айлчлал хийсэн. Төрийн айлчлалын үеэр хоёр улсын хооронд “сайн хөршийн, харилцан итгэлцсэн, түншлэлийн харилцаа”-г тогтоон хөгжүүлэхээ санал нэгтэй мэдэгдэв. Айлчлалын үеэр хоёр улс харилцан ашигтай худалдаа, эдийн засгийн харилцааг эрчимтэй хөгжүүлэх, хамтын ажиллагааг олон салбар, сувгаар, төрөл бүрийн хэлбэрээр өрнүүлэн, худалдаа, хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжиж, уул уурхайн болон боловсруулах үйлдвэрлэлийн салбар дахь хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, байгалийн баялгийг ашиглах, дэд бүтцийг хөгжүүлэх явдлыг хоёр улсын цаашдын хамтын ажиллагааны чухал салбар болгохоор тохиролцсон¹ бөгөөд эдүгээ үр дүнд хүрч эхэллээ. Тухайлбал, Сүхбаатар аймгийн нутагт орших Төмөртэйн овооны цайрын ордод болон Дорнод аймгийн нутаг дахь Тамсаг, Дорноговь аймгийн Зүүнбаяны газрын тосны орд газруудад БНХАУ-аас хөрөнгө оруулж манай улсын зохих байгууллага аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж, Ховд аймгийн Дөргөний усан цахилгаан станцыг 2010 оны 1 дүгээр сард ашиглалтанд оруулжээ.² БНХАУ-ын төрийн тэргүүний айлчлалын үеэр Хятадын тал Монгол Улсад 300 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл олгохоор болсон. Энэхүү зээлийг Эгийн голын усан цахилгаан станцын төсөлд

¹ МУИС-ийн ОУХС-ийн багш, доктор/Ph.D/

ашиглана гэж анх төлөвлөсөн боловч экологийн болон эдийн засгийн үр ашгийн үүднээс зээлийг ашиглах чиглэлээ өөрчилж, баруун бүсийн авто зам барих, төмөр замын тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, мэдээллийн нэгдсэн сүлжээг шинэчлэх, Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцжуулах, Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүсийн дэд бүтцийг сайжруулах зэрэг дэд бүтцийн таван төсөлд хөрөнгө оруулахаар болов.³

Монгол улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр БНХАУ-ын дарга Ху Жинтаогийн урилгаар 2005 онд БНХАУ-д төрийн айлчлал хийсэн. Айлчлалын үеэр гаргасан Монгол улс, БНХАУ-ын хамтарсан мэдэгдэлд, Монгол, Хятадын хооронд 2003 онд сайн хөршийн, харилцан итгэсэн, түншлэлийн харилцааг тогтоосноос хойш хоёр талын улс төрийн итгэлцэл хэлбэрэлтгүй нэмэгдэж, худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа хурдацтай хөгжин, бүх салбарын харилцаа, хамтын ажиллагаа өдрөөс өдөрт идэвхжиж байгааг тэмдэглэн, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа бол Монгол, Хятадын сайн хөршийн, харилцан итгэлцсэн, түншлэлийн харилцааны нэг чухал бүрэлдэхүүн хэсэг мөн гэж талууд санал нэгтэй үзэв. Хоёр улсын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаанд ахиц гарч байгаад сэтгэл ханамжтай байгаагаа талууд илэрхийлж, цаашид байгалийн баялгийг нээн ашиглах, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг гол болгосон харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлж, хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг шинэ агуулга, хэлбэрээр баяжуулах, хамтаар хөгжих, хоёр улс, хоёр ард түмнийг баян чинээлэг болгохын төлөө цаашид хүчин чармайлт гаргахаа талууд санал нэгтэй илэрхийлэв.⁴

БНХАУ-ын дэд дарга Си Жиньпин Монгол улсад 2008 онд албан ёсоор айлчлан, Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяртай албан ёсны хэлэлцээ хийв. Хэлэлцээний үеэр Ерөнхий сайд С.Баяр хүнсний зарим нэр төрлийн бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй нөхцөлөөр Монгол улсад нийлүүлэх, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглэн цахилгаан эрчим хүчний цогцолбор барих хоёр талын тохиролцоог ажил хэрэг болгох зэрэг асуудлыг хөндөж байсан юм. Айлчлалын үеэр “Монгол-Хятадын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр” зэрэг хоёр улсын худалдаа, эдийн засгийн салбарыг хөгжүүлэхэд чиглэсэн 10 гаруй бичиг баримтад гарын үсэг зурсан.⁵

Монгол улсын Ерөнхий сайд С.Баяр 2009 онд БНХАУ-д айлчлал хийж, Баогийн форумд оролцон, БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Жябаотой Саньяа хотод уулзав. Уулзалтын үеэр хоёр тал Монгол улс, БНХАУ-ын найрамдалт харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх талаар ярилцав. Ерөнхий сайд С.Баяр дэд бүтцийн болон байгалийн баялгийг ашиглах салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх, эрчим хүчний цогцолбор барьж БНХАУ-д цахилгаан эрчим хүч экспортлох, нүүрснээс газрын тосны бүтээгдэхүүн болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр хамтран ажиллах талаар саналаа илэрхийлэв.⁶

Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2010 онд БНХАУ-д төрийн айлчлал хийсэн. Айлчлалын үеэр Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж БНХАУ-ын дарга Ху Жинтаотой албан ёсны хэлэлцээ хийж, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн хүрсэн түвшин, цаашид хэрхэн хөгжүүлэх асуудлаар санал солилцон, хоёр орны хоорондын худалдааг нэмэгдүүлэх, уул уурхай, дэд бүтцийн салбар дахь хамтын ажиллагааг эрчимжүүлэх талаар хоёр улсын удирдагчид санал нэгтэй тохиролцлоо.⁷ Хоёр улсын хооронд тогтмол хийгдэж буй өндөр, дээд хэмжээний айлчлал, яриа хэлэлцээ нь хоёр орны бүх талын харилцаа, ялангуяа худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тогтвортой хөгжилд чухал түлхэц үзүүлж байна.

Монгол, Хятадын эдийн засгийн харилцааны чухал бүрэлдэхүүн хэсэг нь БНХАУ-аас Монгол улсад оруулах хөрөнгө оруулалт юм. БНХАУ-аас Монгол Улсад оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ жилээс жилд нэмэгдэн, цар хүрээ нь ч өргөжин тэлэх хандлагатай байна. Хятад улсын хөрөнгө оруулагчид 1990 оноос манай оронд хөрөнгө оруулалт хийж эхэлсэн бөгөөд Монгол Улсад оруулсан гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ болон хөрөнгө оруулалттай компаний тоогоор тэргүүлж буй орон. 1990 оноос 2008 онд манай улсад оруулсан БНХАУ-ын хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 1.68 тэрбум ам.долларт хүрсэн нь манай улсад орсон гадаадын нийт хөрөнгө оруулалтын 56.3 хувийг эзэлсэн.⁸ БНХАУ-ын хөрөнгө оруулагчид геологи, уул уурхайн судалгаа, эрэл хайгуул, олборлолт, худалдаа, нийтийн хоол, инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл, хөнгөн үйлдвэр зэрэг салбарт түлхүү хөрөнгө оруулалт хийж байгаа билээ. Тухайлбал, “Эс энд Ти голд”, “Төмөртэйн хүдэр”, “Доншен газрын тос”, “Петрочайна Тамсаг” ХХК, зэрэг компаниуд геологи, уул уурхай, газрын тосны эрэл хайгуул, судалгаа, олборлолтын салбарт, “Богд холдинг”, “Зүй-лүн” зэрэг компаниуд барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарт, “Монгол хунхуа”, “Топлает текстиль”, “Олбиюти-интернэйшиональ”, “МСХ интернэйшиональ”, “Тяньпин гармент”, “Файвстар” зэрэг компаниуд оёдлын үйлдвэрийн салбарт, “Моннэхий-импекс”, “Эрдос Монголия кашмир продактс” зэрэг компаниуд ноос, ноолуур боловсруулах салбарт тус тус үйл ажиллагаа явуулж байлаа.⁹

Сүүлийн жилүүдэд Хятад улсаас гадаад орнуудад хамгийн ихээр хөрөнгө оруулж буй салбар бол уул уурхай, газрын тосны геологи хайгуул, олборлолт юм. Энэ нь тус улсын эдийн засаг, тухайлбал аж үйлдвэрийн салбар нэн хурдацтай хөгжиж байгаа боловч эрчим хүчний түүхий эд болон бусад төрлийн түүхий эдээр ихээхэн гачигдаж байгаатай шууд холбоотой. Хятад улс нь эрчим хүчний түүхий эдээр маш ихээр дутагдаж буй орон. Дэлхийн газрын тосны нийт нөөцийн 7.7%, байгалийн хийн нийт нөөцийн 7.1% нь тус тус Хятад улсад байдаг ба өнөөгийн техник технологийн хүчин чадлаар дээр дурдсан газрын тосны нөөцийг 15 жил, байгалийн хийн нөөцийг 30 жилийн хугацаанд тус тус олборлон дуусгах төлөвтэй. Хятад улсад шаардагдах газрын тосны 50-иас илүү хувийг импортоор авдаг, харин дэлхийн томоохон газрын тосны ордуудын нөөц нь жил бүр 4-6%-иар хурдацтайгаар багасч, 2010-2015 онд газрын тосны ноцтой хямрал бий болох хандлагатай. Хятад улсад 2010-2020 оны хооронд газрын тосны импортын хэмжээ 31%-60%-иар нэмэгдэх тооцоог хятадын эрдэмтэд гаргажээ.¹⁰ БНХАУ эдийн засгаа тогтвортой хөгжүүлэхийн тулд зайлшгүй шаардагдах эрчим хүчний эх үүсвэр, тухайлбал, газрын тосыг нөөцлөх бодлогыг тууштай баримтлан, газрын тосны нөөцийг хадгалах объектуудыг барих ажлыг хийгээд байгаа билээ. Тухайлбал, 2009 оны 9 дүгээр сард БНХАУ-ын Засгийн газраас Шинжаан-Уйгарын өөртөө засах орны нутаг дэвсгэрт 5.4 сая шоо дөрвөлжин метр багтаамж бүхий газрын тосны нөөцийг хадгалах объектыг барих шийдвэр гаргасан ба энэхүү объектыг барихад 388 сая ам.доллар зарцуулах юм. Одоогийн байдлаар Жэньхай, Хуандао, Далянь, Жоушань зэрэг газруудад газрын тосны нөөц хадгалах объектуудыг барьсан.¹¹ Газрын тосны хайгуул болон үйлдвэрлэлийн хэмжээгээр сүүлийн жилүүдэд Хятад улс дэлхийд 5 дугаарт явж, 2006 оны байдлаар нийт 184 сая тонн газрын тос үйлдвэрлэв. Хятадын газрын тосны томоохон орд газар болох Дачингийн газрын тосны үйлдвэрлэлийн хэмжээ 2003 оноос эхлэн жилээс жилд буурах хандлагатай байна. Тухайлбал, 2003 онд 48.4 сая тонн үйлдвэрлэсэн байхад 2004 онд 46.4 сая тонн, 2005 онд 44.9 сая тонн, 2006 онд 43.4 сая тонн тус тус үйлдвэрлэсэн.¹² БНХАУ-ын

манай улстай ойролцоо орших дөрвөн аж үйлдвэрийн муж 2015 онд 10500, 2020 онд 20 мянган мвт эрчим хүчний дутагдалд орох тооцоо бий.¹³

Газрын тосны геологи хайгуул болон олборлолтын чиглэлээр дэлхийн газрын тосны 10 том компанийн нэг БНХАУ-ын “Дачин Ойлфийлд Лимитед” гэх эх удирдлагатай “Петрочайна Дачин Тамсаг /Монгол/” ХХК манай улстай нэлээд нягт хамтран ажиллаж байна. Хятад улсын хөрөнгө оруулалттай “Петрочайна Тамсаг /Монгол/” ХХК нь Дорнод аймгийн нутаг дахь Тамсагийн сав газарт 2005 оноос газрын тосны хайгуулын ажлыг явуулж, 2007 онд хайгуулын ажилдаа 202 сая ам. долларын хөрөнгө оруулалт хийж, 2008 онд хөрөнгө оруулалтаа урьд оныхоос 1.5 дахин нэмэгдүүлж 350 сая ам. долларт хүргэх бөгөөд улмаар гүйцэтгэх ажлын хэмжээг 1.7 дахин нэмэгдүүлж, олборлолтыг нэг сая баррельд хүргэхээр төлөвлөсөн.¹⁴ 2009 оны байдлаар “Петрочайна Тамсаг /Монгол/” ХХК нь шинээр 300 цооног нэмж өрөмдөж, татварт 10.4 тэрбум төгрөг төлсөн бөгөөд Дорнод аймагт 200 сая төгрөг хандивлажээ.¹⁵ “Петрочайна Дачин Тамсаг” ХХК ийнхүү хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэн сайн ажиллаж байгаа боловч тус ХХК-д ажиллах монгол ажилчдын тоог нэмэгдүүлэн, монгол ажилчдыг мэргэжлээр нь сургах ажилд төдийлөн идэвхи чармайлт гаргахгүй байна. Тухайлбал, 2008 онд хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэн, олборлолтын 125 орчим, хайгуулын 100 цооног өрөмдөхийн тулд нарийн мэргэжил бүхий 4000 хятад ажилчдыг ажиллуулах тухай хүсэлт гаргасан хирнээ 2009 оны байдлаар тус ХХК-д 600 шахам монгол ажилчдыг ажиллуулжээ.¹⁶ Дачин хотод Тамсагаас очсон 6 монгол хүн суралцдаг бөгөөд тэдний хоёр нь бохир нефть дэх хлор, кальц, магни, усан дахь эрдэс баялгийн хэмжээг тогтоох зэрэг лабораторийн ажилд, бусад дөрвөн хүн нь тос олборлох машины оператороор тус тус суралцаж байлаа.¹⁷ “Доншен газрын тос /Монгол/” ХХК нь газрын тосны геологи хайгуул, олборлолтын чиглэлээр манай улстай хамтран ажиллаж байгаа бас нэг хятадын компани юм. Энэ компани нь Дорноговь аймаг дахь Дорноговийн сав газрын Зүүнбаян, Цагаан-Элсний ордоос туршилтын олборлолт явуулж байна. Өнгөрсөн хугацаанд бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуул, олборлолт явуулж манай улсын төсөвт арван тэрбум төгрөгийн орлого оруулжээ.¹⁸ Бүтээгдэхүүн хуваах гэрээний зарчим нь тухайн компани үйл ажиллагаа явуулж, эрсдэлээ зуун хувь хариуцдаг. Тодруулбал, газрын тосны хайгуул, олборлолт явуулж буй “Доншен” компани эрсдэлээ бүрэн хариуцна.

Монгол Улсын Засгийн газар 2007 оны аравдугаар сард газрын тосны үйлдвэр байгуулах тухай шийдвэрийг гаргасан.¹⁹ Эдүгээ Дорнод аймгийн Тамсаг, Дорноговь аймгийн Зүүнбаян зэрэг газрын тосны орд газрууд жилд 1.5 сая орчим баррель газрын тос олборлон авах боломжтой болсон. Гэвч тосоо ямарч боловсруулалт хийхгүйгээр түүхий хэлбэрээр гадаадад шууд экспортлон гаргаж байна. Хэрэв бид өөрийн газрын тосны үйлдвэртэй болвол түүхий газрын тос бус, түүний бүтээгдэхүүн болох бензин, дизелийн шатахууны хэлбэрээр экспортлон гаргахаас гадна дотоодод шаардагдах бензин шатахууны хэрэгцээг ч хангах болно. Манай улс жил бүр нэг их наяд төгрөгийн шатахуун гадаадаас авдаг гэсэн тооцоо бий.²⁰ Ер нь үндэсний аюулгүй байдлын талаасаа аваад үзсэн ч газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээгээ дотоодоосоо хангах нь чухал.

Монголын “Оюуны ундраа ХХК” нь Хятадын Хар-мөрөн мужийн “Хуа-фу ХХК”-тай хамтран газрын тос боловсруулах үйлдвэр байгуулахаар харилцан тохиролцож 2005 оны 5 дугаар сарын 29-ний өдөр шав тавих ёслолын ажиллагаа болсон. “Хуа-фу ХХК”-ний 100 хувийн хөрөнгө оруулалттай энэхүү үйлдвэрийн хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 200 сая ам.

доллар юм. Үйлдвэрийн хүчин чадал нь жилд 1 сая тонн түүхий газрын тосыг боловсруулан 14 нэр төрлийн газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргахаар төлөвлөжээ.²¹ Харамсалтай нь дээр дурдсан газрын тос боловсруулах үйлдвэрийг 2007 онд ашиглалтанд оруулахаар төлөвлөсөн боловч эдүгээг хүртэл ашиглалтанд ороогүй байна. Монгол улсад газрын тосны үйлдвэрийг байгуулах талаар Японы Олон улсын хамтын ажиллагааны банкны санхүүжилтээр “Тоёо инженеринг” корпораци, БНСУ-ын “ENF Mongolia Oil” компани /440.6 сая долларын өртгөөр/ санал оруулсан.²² Дээр дурдснаас үзэхэд манай улсад газрын тосны хайгуул, олборлолт амжилттай явагдаж байгаатай холбогдуулан газрын тосыг боловсруулах сонирхолтой гадаадын хөрөнгө оруулагчид нэмэгдсээр байна.

Монгол улс нүүрсээр баялаг учир нүүрсээ цахилгаан эрчим хүч болгон үйлдвэрлэн /дулааны цахилгаан станц байгуулах/, БНХАУ болон Зүүн хойд Азийн орнуудад шаардагдах цахилгаан эрчим хүчийг өндөр хүчдэлийн шугамаар дамжуулан хүргэснээр Хятад улс болон Зүүн хойд Азийн улс орнуудын эдийн засгийн хөгжилд их тус болохоор барахгүй, манай улсын олон хүнийг ажлын байраар хангах асуудлыг шийдэж, улмаар Монгол улсын үндэсний аж үйлдвэрийг хөгжүүлэхэд шаардагдах эрчим хүчийг бий болгосноор эдийн засагт их ашигтай байх болно.

Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболд Монгол улсад 2006 оны 12 дугаар сард айлчилсан БНХАУ-ын “Улсын цахилгаан сүлжээ” корпорацийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзахдаа, “түүхий нүүрс хямдхан экспортлох бус цахилгаан эрчим хүч экспортлох нь илүү ашигтай” гэж тэмдэглэв. Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр 2009 оны 4 дүгээр сард БНХАУ-д айлчлахдаа Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Жябаотой уулзаж, дэд бүтцийн болон байгалийн баялгийг ашиглах салбарт хамтран ажиллаж, нэмүү өртөг шингээсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглэн цахилгаан, эрчим хүчний цогцолбор барьж Хятад улсад цахилгаан эрчим хүч экспортлох, нүүрснээс газрын тосны болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр хамтран ажиллах талаар саналаа илэрхийлэн ярилцав.²³

Шивээ-Овоогийн нүүрсний орд газрыг түшиглэн “Уурхай, цахилгаан станцын цогцолбор” төслийг манай улс БНХАУ-тай хамтран хэрэгжүүлэхээр харилцан тохиролцсон бөгөөд Түлш, эрчим хүчний яам, “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ” ТӨХК, БНХАУ-ын “Улсын цахилгаан сүлжээ” компани, “Лу-нэн групп”-ийн хооронд 2006 оны 6 дугаар сард хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зуржээ. Энэхүү төслөөр жилд 15 сая тонн нүүрсийг тус бүрдээ олборлох гурван ил уурхай, 3600 мвт хүчин чадалтай дулааны цахилгаан станц байгуулах ба үүнд нийтдээ 2.9 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай. Дээрх төслийн талаар Монгол Улсын Засгийн газар 2009 оны 12 дугаар сард хуралдаж, төслийн явц, ажлын хэсгийн ажлын тайлантай танилцаж, цаашид хийх ажлын талаар чиглэл өглөө.²⁴ Түүхий нүүрс экспортоор шууд гаргавал эдийн засгийн хувьд ашиггүй, хөрөнгө оруулалтын дараагийн боломжуудаа алдах учир нүүрсээ түүхийгээр бус боловсруулалт хийсний дараа гаргах нь зүйтэй. Говь нутагт усны гачаалтай нь дулааны цахилгаан станц болон нүүрсний боловсруулах үйлдвэр байгуулах ажилд саадтай ч хангайн бүсийн гол мөрнөөс ус татсанаар шийдэж болно. Тухайлбал, Орхон, Хэрлэн голоос ус татах, мөн Улаанбаатар хотын хэрэглэсэн усыг цэвэршүүлэн хоолойгоор дамжуулан үйлдвэрлэлд ашиглах төслүүдийг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай хэмээн зарим эрдэмтэд үздэг.²⁵ Монголын усны үндэсний хөтөлбөр, Японы “CTI Engineering” компани хамтран судалгаа хийж, Хэрлэн голоос урагш ус татах шинжлэх ухааны үндэс байна гэсэн дүгнэлт гарган, 1000

гаруй км үргэлжлэх уг урсац Багануур-Шивээ-Овоо-Цагаан Суварга-Оюу толгой-Сайншанд-Замын-Үүд хүрэхээр тэд тооцоолжээ. Хэрлэнгийн ус өвөлдөө татардаг аж. Ийнхүү боолт хийснээр Хэрлэнгийн ус хэвийн болж хоёр талын ач холбогдолтой, байгаль, экологид ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй гэсэн үнэлэлтийг эрдэмтэн судлаачид хийжээ.²⁶ Хятад улсын хойт нутаг сүүлийн жилүүдэд усаар гачигдан, өмнө зүгийн гол мөрнөөс усыг хойд зүг рүү татах ажлыг хэдэн жилийн өмнө эхэлсэн бөгөөд энэ талаар нэлээд туршлага хуримтлуулсан. Иймээс Орхон, Хэрлэн голоос ус татах дээрх төслүүдийг хэрэгжүүлэхэд Хятад улстай хамтран ажиллах боломжтой. Одоо Хятадын компаниуд Гашуун сухайт, Нарийн сухайт зэрэг хилд ойр ордууд болон Шивээ-Овоогийн /Шинэ усны хотгорын орд/ 600 сая тонн нүүрсний нөөцтэй ордыг ашиглаж байгаа буюу ашиглахад бэлтгэж байгаа юм.²⁷ БНХАУ Монгол улсаас эрчим хүчний болон металлургийн сайн чанарын нүүрс авах сонирхолтой. Монгол улсад санал болгосон төмөр замуудаа өөрийн сүлжээтэй холбож чадвал дэлхийн зах зээлээс хоёр дахин хямд үнээр нүүрс авах боломжтой бөгөөд нүүрс тээвэрлэх гарцаа Эрээний боомтоос баруун зүгт холдуулснаар зардлаа хэмнэхийн зэрэгцээ ачааллаа даахгүй байгаа Хятадын зүүн хойд нутгийн төмөр замын сүлжээнээс баруун хойд сүлжээнд шилжүүлэхийг сонирхож байна.

БНХАУ-ын Зүүн хойд хэсэгт орших аж үйлдвэр нэлээд хөгжсөн Хар-мөрөн муж 2006 оны 6 дугаар сарын байдлаар Монгол улсад нийт 200 сая гаруй ам.долларын хөрөнгө оруулжээ.²⁸ Тус мужийн уул уурхайн корпораци 1999 оноос Монголд уул уурхайн чиглэлээр хөрөнгө оруулж эхэлсэн бөгөөд тухайлбал, Төмөртэйн ордны төмрийн хүдрийг олборлох, Баян голын төмрийн орд газрын геологи хайгуул хийх эрхийг тус тус авсан. Төмөртэйн ордны нийт нөөцийн хэмжээ 23 сая тонн, энэхүү төмрийн ордыг ашиглалтанд оруулснаар Хар-мөрөн муж жилдээ Монгол улсаас төмрийн хүдэр 2.2 сая тонн, төмрийн баяжмал 2.7 сая тонн импортлон авах боломжтой хэмээн хятадын эрдэмтэд үзэж байгаа бөгөөд Хар-мөрөн мужийн уул уурхайн корпораци ӨМӨЗО-ы Бугатын төмөрлөгийн корпорацитэй хамтран Төмөртэйн төмрийн хүдрийн нөөцийг ашиглана гэжээ.²⁹ ӨМӨЗО-ы Бугатын төмөрлөгийн корпораци Төмөртэйн уурхайгаас төмрийн хүдэр авах талаар Төмөртэйн төмрийн хүдрийн үйлдвэртэй 20 жилийн хугацаатай гэрээ байгуулжээ.³⁰

Хөрш орнуудын эрчим хүчний эх үүсвэр, байгалийн нөөц баялаг болон түүхий эдийг ашиглах зорилгоор Хар-мөрөн мужаас гадаад орнуудад хийх хөрөнгө оруулалтын хэмжээ 5 тэрбум орчим ам.доллар болж, нийт 50 төслийг боловсруулан хэрэгжүүлж байна. Эдгээр төслийн дагуу хөрш орон болох ОХУ, Монгол улсын байгалийн нөөц баялгийг нээн ашиглаж байна. Хар-мөрөн мужийн захиргаа ОХУ-ын Алс Дорнодын бүс нутагт болон Монгол улсад хийх геологи хайгуулын бэлтгэл ажилд зориулан 3 сая гаруй юаний хөрөнгийг гаргасан байхаас гадна аж ахуйн нэгж байгууллага, үйлдвэр аж ахуйн газруудад гадаад орны уул уурхайг ашиглах лицензийг худалдан авахад идэвхитэй дэмжиж, тухайлбал 2003-2004 онд ОХУ-ын алт, зэс, никелийн уурхай болон Монгол улсын төмрийн уурхайг ашиглах лицензийг худалдан авахад мужийн төсвөөс нийт 45.01 сая юань гарган санхүүгийн дэмжлэг үзүүлжээ.³¹ Хар-мөрөн мужийн хөрөнгө оруулагчид Монгол улсад хөрөнгө оруулан байгуулсан анхны хамтарсан үйлдвэр нь ясны гурилын үйлдвэр байсан бөгөөд тус үйлдвэрт нийт 70 мянган ам. долларын хөрөнгө оруулснаас хятадын тал 35 мянган ам. долларын хөрөнгө оруулжээ.³² Монгол улсын Дорнод аймгийн Халх гол суманд 2009 онд 1.5 гектар талбай бүхий газарт сэрүүн бүс нутагт ургадаг цагаан будааг туршилтын хэлбэрээр тариалж, 60 центнер ургац хурааж авсан.³³ Энэ нь манай улс жил бүр их

хэмжээний мөнгө хөрөнгө зарцуулан гадаадаас импортлон авдаг хүнсний нэг төрлийн чухал бүтээгдэхүүнээр ойрын ирээдүйд өөрсдийн хэрэгцээг хангах боломж нээгдэж буйг харуулав. Сэрүүн нутагт ургадаг сортын цагаан будааг Хятад улсын Хар-мөрөн мужийн “У-чан” хэмээх газарт олон жил ургуулан, энэ талаар арвин туршлага хуримтлуулсан. Иймээс манай оронд цагаан будааг тариалах талаар Хар-мөрөн мужтай хамтран ажиллаж, үйлдвэрлэсэн экологийн цэвэр бүтээгдэхүүнээрээ дотоодын хэрэгцээг хангахаас гадна Хятад улс болоод Зүүн хойд Азийн орнуудад экспортлох нь Зүүн хойд Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны нэг хэлбэр болох юм.

Монгол улсын УИХ-ын дарга Д.Дэмбэрэл тэргүүтэй төлөөлөгчид 2008 оны 12 дугаар сард Хятад улсын зүүн хойд бүс нутгийн төв хэсэгт орших Жилинь мужид зочлон, Монгол Улс БНХАУ-ын Жилинь мужаар дамжуулан Зүүн хойд Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны интеграцчилалд идэвхтэй оролцох сонирхолтой байгаагаа илэрхийлэв.³⁴ Жилинь мужийн төв Чанчунь хотод жил бүр зохион байгуулагддаг Зүүн хойд Азийн орнуудын хөрөнгө оруулалт, худалдааны үзэсгэлэн яармагт манай улс идэвхитэй оролцдог. 2008 онд болсон энэхүү яармагт Монголын 50 гаруй худалдааны төлөөлөгчид оролцон Монгол улсын үйлдвэр худалдааны танхим, Жилинь мужийн Шинжлэх ухаан техникийн газартай “Шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр” байгуулан эрдэм шинжилгээний болон техникийн сургалтын ажлыг хамтран явуулахаар тохиролцов.³⁵ 2008 оны байдлаар Жилинь мужийн 6 үйлдвэр аж ахуйн нэгж уул уурхайн олборлолт, авто зам барих, төмөрлөгийн үйлдвэр зэрэг чиглэлээр Монгол улсад нийт 12.35 сая ам. долларын хөрөнгө оруулсан. Жилинь муж, Дорнод аймагтай хамтран 2008-2009 онд 0.4 сая тонн, 2010-2011 онд 4 сая тонн нүүрсний олборлолт тус тус хийхээр тохиролцон хэлэлцээр байгуулав.³⁶

Монгол, Хятадын хамтарсан цайрын баяжмалын үйлдвэр 2005 оны 8 дугаар сардашиглалтанд орлоо. Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших Төмөртэйн овооны цайрын ордод түшиглэн Монгол улсын “Металлимпекс” ХХК, БНХАУ-ын “Өнгөт төмөрлөгийн уул уурхай” ХХК хамтран байгуулсан энэхүү үйлдвэр жилд 300 мянган тонн цайрын хүдэр олборлож, 50 хувийн агуулга бүхий цайрын 70 мянга орчим тонн баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай. Монгол, Хятадын хамтарсан энэхүү үйлдвэрийн 51 хувийг БНХАУ, 49 хувийг Монгол Улс эзэмших “Цайртминерал” ХХК болон байгуулж 2000 онд анхны хөрс хуулалтыг хийж үйлдвэрийн шавыг тавьсан юм.³⁷ Төмөртэйн овооны цайрын орд дахь баяжмалын үйлдвэр байгуулж ашиглалтанд оруулсан нь Монгол, Хятад хоёр улсын эдийн засгийг хөгжүүлэхэд зохих хувь нэмэр оруулж байна. 2006 оны байдлаар энэ үйлдвэрт монголын 215 ажилчин, хятадын 62 инженер техникийн ажилтан ажиллаж байсан бөгөөд Монгол Улсын ДНБ-ний 2-2.5%-ийг эзэлж байсан.³⁸ Өнөөдөр цайрын эрэлт хэрэгцээ дэлхий нийтэд, ялангуяа эдийн засаг нь эрчимтэй хөгжиж буй Хятад улс, Зүүн Азийн орнуудад их байгаа юм. Цайр нь өнгөт төмөрлөгийн үйлдвэрлэлийн болон автомашин, компьютерийн эд ангийн үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд болгон өргөн хэрэглэгддэг.

Монгол улсын Ерөнхий сайд С.Баяр 2009 оны 4 дүгээр сард БНХАУ-д хийсэн айлчлалынхаа хугацаанд ӨМӨЗО-нд зочлон, уул уурхайн олборлолтын салбар дахь хамтын ажиллагааны талаар тус өөртөө засах орны удирдлагатай ярилцав. С.Баяр хэлэхдээ: “... бид уул уурхайн салбарыг хөгжүүлэхдээ түүхий эдээр биш, нэмүү өртөг шингээж боловсруулсан байдлаар гаргаж ашиглах бодлого баримталдаг. Манай орны байгаль цаг уур танайхтай ойролцоо учир орд газруудын

том төслүүдийг хэрэгжүүлэхдээ байгалийн нөхөн сэргээлт зэрэг асуудалд суралцах, хамтран ажиллах шаардлага гарч байна” гэжээ.³⁹ Монгол Улс, БНХАУ-ын ӨМӨЗО-ны хооронд худалдаа, эдийн засгийн нягт харилцаатай. Сүүлийн жилүүдэд ӨМӨЗО-оос манай улсад оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ эрс нэмэгдэн, 2007 оны байдлаар ӨМӨЗО-ны 27 компани, нийт 258 сая ам. долларын хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд энэ нь тус өөртөө засах орноос гадаад орнуудад оруулсан хөрөнгө оруулалтын нийт хэмжээний 55.5%-ийг эзлэв.⁴⁰ Хятад улсын ӨМӨЗО-ны “Yili” сүүний корпораци Монгол Улсын Хүнс ба Хөдөө аж ахуйн яамтай жилд 100 мянган тонн сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулж, “Yili” сүүний корпораци үүнд 100 сая ам.долларын хөрөнгө оруулах тухай хэлэлцээрт 2006 онд гарын үсэг зурсан.⁴¹ “Yili”, “Monmilk” зэрэг ӨМӨЗО-ны томоохон сүүний корпорацид үйлдвэрлэсэн зарим бүтээгдэхүүн сүүлийн жилүүдэд манай улсын зах зээлд худалдаалагддаг болсон боловч 2008 оны намар БНХАУ-д үйлдвэрлэсэн хүүхдийн хуурай сүүн тэжээлд меламина илэрсэн явдлаас хойш дээр дурдсан бүтээгдэхүүнийг манай зах зээлээс татсан.⁴² 2009 онд хоёр тал уул уурхай, үйлдвэр, барилга, дэд бүтцийн салбарт нийт 125 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийх хэлэлцээр байгуулав. Тухайлбал, жилд 1 сая тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай, 69.62 сая ам.долларын хөрөнгө оруулалттай Монгол, Хятадын хамтарсан цементийн үйлдвэр байгуулахаар тохиролцов.⁴³ Монгол Улс, БНХАУ-ын ӨМӨЗО-ны хоорондын хилийн шугам нь Монгол, Хятад хоёр улсын хилийн шугамын 68.3 хувийг эзэлж, манай улсын 6 аймаг, 26 сум нь ӨМӨЗО-ны 6 аймаг, 15 хошуутай хил залгаж, 10 хилийн боомт ажилладаг нь хоёр талын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг хөгжүүлэхэд таатай нөхцөл буй болгов. Замын-Үүдээр дамжиж Монгол Улсын эдийн засаг, бизнесийн гол бараа бүтээгдэхүүн орж ирдэг. Тухайлбал, “40 мянган айлын орон сууц” хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш барилгын материалын 90 орчим хувь нь Эрээн, Замын-Үүдээр дамжин орж, мөн хүнсний бараа бүтээгдэхүүний 70-80 хувь орж ирдэг гэсэн тооцоо байдаг.⁴⁴ Замын-Үүд, Улаанбаатар, Сүхбаатарын чиглэлийн төмөр замыг хоёр урсгалтай болгож, Замын-Үүд, Улаанбаатарын хооронд тавьж байгаа авто замыг ашиглалтанд оруулснаар Ази, Европыг холбосон төмөр зам болоод авто замын сүлжээ бий болох боломж бүрдэх юм. Энэхүү замын сүлжээ нь манай улсын эдийн засгийг хөгжүүлэхэд тухайлбал, гадаадын хөрөнгө оруулалтыг татан оруулахад чухал ач холбогдолтой. БНХАУ-ын талаас Эрээн хотод авто болон төмөр замын олон урсгалтай зам нэгэнт байгуулж эхэлсэн тул бид ч хоцролгүйгээр өмнөөс нь угтуулан тавих шаардлагатай. ӨМӨЗО-ы Эрээн хот 2006 оноос эхлэн уул уурхайн чиглэлээр манай улсад хөрөнгө оруулалт хийж, 2008 оны байдлаар Эрээний 4 компани төмөр, цайрын хүдрийн олборлолтын үйл ажиллагааг явуулдаг бөгөөд нэг компани нь 5.82 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж Монгол Улсын Тамирын гол зэрэг 3 орд газарт 40 жилийн хугацаатай олборлолтын эрх авч үйл ажиллагаагаа явуулж байна.⁴⁵

Аливаа улс гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжсэнээр тус улсын төрийн болон хувийн компаниуд бизнесийн үйл ажиллагаагаа явуулах, өргөжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэртэй болох нөхцөлийг бүрдүүлэх боловч гадаадын хөрөнгө оруулалт нь тэр бүр эдийн засаг, эрх зүйн зэрэг үр дүнг бий болгодоггүй байна. Зарим нөхцөлд эдийн засаг гадаадаас хамааралтай болох, байгаль орчныг сүйтгэх, импорт хэт нэмэгдэх зэрэг эдийн засгийн сөрөг үр дагаварыг үүсгэдэг.

Манай улс дэлхийн бусад орны нэгэн адил гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжиж үр шимийг нь хүртэх зорилгоор гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой хууль тогтоомж гаргах, гадаадын хөрөнгө оруулалт эрхэлсэн байгууллагыг бий болгон ажиллуулах, хөрөнгө оруулалтын нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх зэрэг чухал арга хэмжээ авсаар ирсэн. Үүний үр дүнд 1990-ээд оноос хойш Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалт жилээс жилд өсч байгаагаас ихэнх нь ашигт малтмал, уул уурхайн салбарт ноогдож байна.

Монгол Улс, БНХАУ-ын харилцаа хөгжлийн шинэ үе шатандаа дэвшин орж буй өнөө үед Монгол-Хятадын эдийн засгийн харилцаа чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд БНХАУ-аас оруулж буй хөрөнгө оруулалт манай улсын эдийн засгийг хөгжүүлэхэд зохих хувь нэмэр оруулдаг. Иймээс энэхүү хөрөнгө оруулалтыг эдийн засгийн чухам аль салбарт түлхүү оруулж, хөрөнгө оруулалтын эерэг болон сөрөг талуудыг сайтар судлах нь чухал. Хөрөнгө оруулалтыг харилцан үр ашигтай, тогтвортой, зөв зохистой оруулах нь манай хоёр орны эдийн засгийг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэхээс гадна хоёр орны ард түмний итгэлцэл, эв найрамдлыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Эшлэл, зүүлт

1. Монгол Улс, БНХАУ-ын хамтарсан мэдэгдэл, Улаанбаатар хот, 2003 оны 6 дугаар сарын 5-ны өдөр
2. <http://www.sina.com.cn> 2010.01.29
3. "Өдрийн сонин" 2009.10.16
4. Монгол Улс, БНХАУ-ын хамтарсан мэдэгдэл, Бээжин хот, 2005 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр
5. <http://www.xx.gov.cn> 2008-06-20, "Өдрийн сонин" 2008.06.20, 蒙古消息 / "Монголын мэдээ" сонин/, 2008.06.25
6. <http://www.xinhuanet> 2009.04.17, "Өдрийн сонин" 2009.04.20
7. <http://www.mfat.gov.mn> 2010.05.04
8. 蒙古消息 / "Монголын мэдээ" сонин/, 2009.08.28, "Өнөөдөр" сонин, 2009.09.16
9. "Олон улс судлал" сэтгүүл, 2006. №3, 9 дэх тал
10. Blue book of energy, Annual report on China's energy development (2008), Beijing, 2008, p.316
11. "Өдрийн сонин" 2009.09.26
12. Blue book of energy, Annual report on China's energy development (2008), Beijing, 2008, p. 152-153
13. "Өдрийн сонин" 2009.12.01
14. "Northeast Asia Forum" сэтгүүл, 2008, Vol.17 No 2, p.22, "Өнөөгийн Хятад" сэтгүүл, 2007, No 1, 6 дахь тал
15. "Өдрийн сонин" 2009.11.04
16. "Дорнод сонин" 2009.12.04
17. "Өдрийн сонин" 2008.04.24
18. "Өдрийн сонин" 2008.10.22
19. "Өдрийн сонин" 2009.10.21
20. Мөн тэнд
21. 刘清才、高科等著 "北·地·政治与中国地·略", 天津, 2007 /"Зүүн хойд Азийн геополитик ба Хятад улсын геостратеги" Тяньжин, 2007/, 302-303 дахь тал., "Northeast Asia Forum" 2008, Vol.17, No2, p.22
22. "Өнөөдөр сонин" 2009.06.24 "Өдрийн сонин" 2009.04.20
23. "Өдрийн сонин", 2009.04.20
24. <http://www.open-government.mn> 2009 оны 12 сарын 09

25. "Өдрийн сонин" 2009.12.01
26. "Өнөөдөр сонин", 2007.04.17
27. "Өдрийн сонин" 2009.12.01
28. "Northeast Asia Forum" 2008, Vol.17, No2, p.22
29. Мөн тэнд
30. <http://www.nmgswt.gov.cn>, 2006.10.15
31. "Northeast Asia Forum" 2008, Vol.17, No2, p.21
32. "Northeast Asia Forum" 2008, Vol.17, No2, p.22
33. "Өдрийн сонин" 2009.10.10
34. "Өдрийн сонин" 2008.12.16
35. "Чанчунь хотын оройн сонин" 2008.09.03
36. Мөн тэнд
37. Монголын уул уурхай, УБ, 2002, 296 дахь тал., "Өнөөдөр сонин", 2005.08.31
38. <http://mn.mofcom.gov.cn>, 2006.11.01
39. "Өдрийн сонин" 2009.04.18
40. <http://www.drmining.com>
41. <http://www.clii.com.cn>, 2006.10.08
42. "Өдрийн сонин", 2009.02.24, 10.24
43. <http://www.im.mofcom.gov.cn> 2009.07.10
44. "Өдрийн сонин" 2008.10.27
45. <http://www.nmgswt.gov.cn> 2008.11.21
46. "Өдрийн сонин" 2007.11.27